

Авлигатай тэмцэх газар сүүлийн жилүүдэд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, авлигын гэмт хэрэгт холбогдсон этгээдэд хариуцлага тооцон, төрд учирсан хохирол нөхөн төлүүлэх ажлын хүрээнд дараах үр дүнг гарган ажиллав.

**₮5.02** их наяд

Авлигын гэмт хэргийн улмаас  
2022 онд улсын төсөвт учирсан  
нийт хохирол

АТГ-аас 2022 онд мөрдөн шалгах  
ажиллагааны явцад нөхөн  
төлүүлсэн мөнгөн дүн

**₮2.4** их наяд

## ₮2.4 ИХ НАЯД ХЭР ИХ МӨНГӨ ВЭ?

Бойнг 737 макс загварын  
нисэх онгоц

**8 ш** худалдаж авах



0-3 насны хүүхэдтэй 632,542  
ээж бүрт 1 удаа тэтгэмж

**₮4,498,316** олгох



348МВт-ын хүчин чадалтай  
дулааны станц


**9 ш** шинээр барих



36 хүний суудалтай YINLONG  
ENERGY цахилгаан автобус

**4,746 ш** худалдаж авах



Авлигыг таслан зогсооход хүн бүрийн оролцоо чухал  110





### Авлигаас урьдчилан сэргийлэх 67 ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭВ

Авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй үзүүлэх, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, албан тушаалтны ёс зүй, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах чиглэлээр давхардсан тоогоор төрийн 67 байгууллага, албан тушаалтанд Зөвлөмж хүргүүлж үр дүнт тооцон ажиллаж байна.



### Хяналт шалгалтаар 2.1 тэрбум төгрөгийн ТАТВАРЫН ЗӨРЧИЛ ИЛРҮҮЛЭВ

Өөрийн болон гэр бүлийн гишүүдийн татвар ногдуулах орлогоо үнэн зөв тайлагнаагүй байж болзошгүй нөхцөл байдал илэрсэн тул Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлд зааснаар 3 мэдүүлэг гаргагчид холбогдох мэдээллийг Татварын ерөнхий газарт шилжүүлснээр шалгалтаар нийт 2 132 072 560 төгрөгийн татварын зөрчил илэрч, нийт 136 380 970 төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна.



### Албан тушаалтнуудын болон УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдийн ХОМ-ИЙГ БҮРТГЭЖ, НИЙТЭД МЭДЭЭЛЭВ

Хуулийн хугацаанд улсын хэмжээнд нийт төрийн болон нутгийн захиргааны нийт 127 байгууллагын 50258 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ мэдүүлж, баталгаажуулсныг бүртгэв.

Төрийн болон нутгийн захиргааны албан тушаалтны 2023 оны ХОМ-ийн хураангуйг <http://www.xasxom.iaac.mn> цахим хуудсанд 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдөр нээлттэй байршуулав.

УИХ-ын 2024 оны сонгуульд өрсөлдөхөөр 1433 нэр дэвшигчээс ХОМ-ийг нь хуулийн хугацаанд бүртгэж, лавлагааг хуульд зааснаар Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн. УИХ-ын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэж, 1337 нэр дэвшигчид үнэмлэх олгосон тухай Сонгуулийн ерөнхий хорооны тогтоолыг үндэслэн нэр дэвшигчдийн ХОМ-ийн хураангуйг <http://xasxom.iaac.mn/> цахим системд 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдөр нээлттэй байршуулав.



### Авлигын эсрэг сургалтад 23144 ХҮНИЙГ ХАМРУУЛАВ

Авлигын хор аюулыг ухуулан таниулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сургалчлах сургалтыг цахимаар болон танхимаар нийт 199 удаа зохион байгуулж, 23144 хүнийг хамруулав. Үүнд төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 16442, хувийн хэвшлийн байгууллагын 80, оюутан залууст зориулсан 725, иргэдэд зориулсан 236, нийтийн албан тушаалтан 3318, эрх бүхий албан тушаалтан 2343 тус тус хамрууллаа.

Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багш бэлтгэх үйл ажиллагааны хүрээнд нийт 36 байгууллагын 42 албан хаагчийг сургагч багшийн сургалтад хамруулж, гэрчилгээ олгов.

## 1.7 сая долларын хохирлыг МОНГОЛ УЛСАД ЭРГЭН ТӨЛҮҮЛЭВ

АТГ-ын Гүйцэтгэх ажлын хэлтэс, Мөрдөн шалгах хэлтсээс гадаад улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагатай хамтран ажилласнаар Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн гүйцэтгэгчээр хуурамч баримт бичиг бүрдүүлж хууль бусаар шалгарсан БНСУ-ын “Taihan Cable & Solution” компани нь гэрээнд тусгагдсан төслийн хөрөнгийг үр дүнгүй захиран зарцуулан улсад их хэмжээний хохирол учруулсан болохыг тогтоон тус компаниас 1.7 сая ам.долларын хохирлыг Монгол Улсад эргүүлэн төлүүлж, төсвөөс дээрх зээлийн төлбөрийн хүүг төлж байсныг зогсоолоо.

### Дансны хуулга

Хамрах хугацаа: 2024/06/19 - 2024/06/20  
Данс: Цахим эрүүл мэнд төсөл  
Эхний үлдэгдэл: 7,296.35  
Валют: USD  
Эцсийн үлдэгдэл: 1,725,656.35

№	Огноо	Харцсан дансны нэр	Орлого	Зарлага	Үлдэгдэл (Валют)	Гүйлгээний утга
1	2024-06-19		1,718,360	0	1,725,656.35	ННЕР PJT RETURN OF DOWN PAYMENT.
2	НИЙТ ДҮН		1,718,360	0	1,725,656.35	